

МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГО, СТРАТЕГИ

Б.ОДБААТАР Н.БАЛЖИННЯМ

Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа

Ховд аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Товч агуулга. Энэхүү Монгол Улсад үйлдэгдэн гарч байгаа зам тээврийн осол, хэрэг, түүний шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, цаашид замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад анхаарах асуудлын талаар авч үзэхийг зорилоо.

Түлхүүр үгс. Зам тээврийн осол, замын хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүй байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах.

Оршил

Дэлхий дахинд зам тээврийн ослын улмаас жилд 1.2 сая гаруй хүн амь насдаа алдаж, 50 сая гаруй хүн бэртэж, гэмтэн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн зэрэгцээ 5-29 насны хүүхэд, залуучуудын үхлийн үндсэн шалтгаан нь зам тээврийн осол болж байгаа⁴¹ нь сэтгэл эмзэглүүлмээр тоо юм.

Зам тээврийн осол нь зүрхний шигдээс, сэтгэлийн дарамтын дараа хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болох төлөвтэй байгаа бөгөөд зам тээврийн ослоор нас барагсдын 90 гаруй хувь нь буурай болон хөгжиж байгаа улс оронд ногдож, жилд нийт 65 тэрбум ам. долларын хохирол учирч байгааг НҮБ-аас онцлон тэмдэглэж, 2010 онд Ерөнхий Ассамблейн хуралдаанаас 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жилүүд” болгон зарлаж 64/255 дугаар тогтоолыг гаргаж, зам тээврийн ослыг эрс багасгаж, нас баралтыг 50 хувиар бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 146 дугаар тогтоолоор НҮБ-ийн 2010 оны 64/255 тогтоол, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.2.3 дахь заалт -ыг тус тус хэрэгжүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги (2012-2020 он)”, стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө -г тус тус батлан гаргаад байна.

Манай улсын хувьд зам тээврийн осол, зөрчлийн тоо жилээс жилд нэмэгдэж, түүнээс шалтгаалах нас баралт өсөх хандлагатай байна. Гарч байгаа нийт осол, гэмтлийн 18.9 хувийг зам тээврийн осол эзэлж байна.

Зам тээврийн осолд өртөх, гэмтэх явдал их байгааг албан ёсны статистикийн мэдээ, хүн амын дунд хийсэн судалгаа харуулж байна. Зам тээврийн осол, гэмтэл үүсэхэд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь:

1. Хурд хэтрүүлэх (22.7 хувь)
2. Согтууруулах ундаа хэрэглэх (9.1 хувь) зөрчил болж байгаагаас гадна
3. Хот төлөвлөлт өнөөгийн шаардлага хангахгүй
4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулж байгаа хууль, дүрэм, журам, стандартын биелэлт хангалтгүй,
5. Тээврийн хэрэгслийн парк хэт хуучирсан,
6. Хөдөлгөөнд оролцогчдын соёл, боловсрол дутмаг
7. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй зэрэг дутагдал байгаа нь судалгаагаар тогтоогдсон болно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь замын хөдөлгөөнийг зохицуулагч,

⁴¹ Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги /2012-2020 он/ Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолын хавсралт. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn>

жолоочийн үүрэг мэт ойлголт байсан бөгөөд орчин үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам-Орчин” гэсэн харилцан уялдаа бүхий цогц асуудал гэдгийг эрдэмтэд тогтоогоод байна.

Тайланд Улсын Бангкок хотод 2010 онд зохион байгуулагдсан Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн комиссын Бүс нутгийн замын хөдөлгөөний шинжээч нарын уулзалтаар улс орон бүрт зам тээврийн ослын нас баралтыг бууруулах “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөмж”-ийг гаргасан болно.

Зам тээврийн осолд өртөх, гэмтэх явдал их байгааг албан ёсны статистикийн мэдээ, хүн амын дунд хийсэн судалгаа харуулж байна. Тухайлбал, 15-64 насны иргэдийн 4 хувь нь сүүлийн 12 сарын дотор зам тээврийн осолд өртсөн байна. Зам тээврийн осол, гэмтэл үүсэхэд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь хурд хэтрүүлэх (22.7 хувь), согтууруулах ундаа хэрэглэх (9.1 хувь) зөрчил болж байгаагаас гадна хот төлөвлөлт өнөөгийн шаардлага хангахгүй, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулж байгаа хууль, дүрэм, журам, стандартын биелэлт хангалтгүй, тээврийн хэрэгслийн парк хэт хуучирсан, хөдөлгөөнд оролцогчдын соёл, боловсрол дутмаг, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй зэрэг дутагдлууд байгаа нь судалгаагаар тогтоогдсон.

Монгол Улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, стратегийн тухайд авч үзвэл нэн тэргүүнд салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдааг ханган “Хүн-Тээврийн Хэрэгсэл-Зам-Орчин” гэсэн системийн аюулгүй байдлыг цогц арга хэмжээг бүрдүүлэх замаар зам тээврийн ослын сөрөг үр дагаврыг мэдэгдэхүйц хэмжээгээр багасгахад чиглэсэн бодлого чухал байна.

Үүний тулд бидний үзэж байгаагаар дараах стратеги зорилтыг дэвшүүлэн үр дүнтэй ажиллах шаардлагатай. Үүнд:

Хөдөлгөөний аюулгүй байдлын менежмент.

- Аюулгүй зам, орчин.
- Аюулгүй тээврийн хэрэгсэл.
- Хөдөлгөөнд оролцогчдод зориулсан үйл ажиллагаа.
- Ослын дараах тусламж, үйлчилгээ.

Монгол Улсын хэмжээнд 2012-2020 онд зам тээврийн ослын улмаас нас барсан болон хүнд гэмтсэн хүний тоог тус бүр 50 хувиар бууруулах нөхцөл бүрдэх юм. Мөн стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлахад чиглэсэн хөдөлгөөний аюулгүй байдлын менежмент чухал байна. Үүнд:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх.

Мэргэжлийн хүний нөөцийг тусгайлан бэлтгэх.

Эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох.

Хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийг үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулах байгууллагыг бий болгон, холбогдох байгууллагуудын үүрэг, хариуцлагыг оновчтой, зөв тодорхойлох.

Үндэсний хэмжээний стратеги хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох.

Авто тээврийн салбарын даатгалын системийг боловсронгуй болгох.

Судалгаа, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг цогц байдлаар судлах судалгаа шинжилгээний бие даасан, хараат бус албыг бий болгох шаардлагатай.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах менежментийн зорилт тус бүрээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Нэг: Аюулгүй зам, орчин.

Авто замын сүлжээний аюулгүй байдлыг нийт хөдөлгөөнд оролцогчид, ялангуяа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон явган, дугуйгаар зорчигчдод зориулан сайжруулах.

Хот төлөвлөлтийн хууль тогтоомж, ерөнхий төлөвлөгөөг боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог бий болгох.

Хотын блок хоорондын зайг 150 метрээс ихгүй байхаар төлөвлөх.

Хотын төвийн хөдөлгөөний ачааллыг “хэрэглэгч төлдөг” зарчимд шилжүүлэх замаар багасгах.

Замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах үед орчин үеийн техник технологи, стандартыг хэрэглэж аюулгүй байдлын шаардлагыг заавал хангах.

Хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа хийдэг байх, замын сүлжээний төлөвлөлтийг зорчигч болон ачаа тээврийн төлөвлөлттэй нягт уялдуулах.

Хоёр: Аюулгүй тээврийн хэрэгсэл.

Дэлхий нийтээр мөрдөж байгаа стандарт, шаардлага, орчин үеийн технологид нийцүүлэн авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг дээшлүүлэх.

Тээврийн хэрэгслийг импортоор оруулах асуудлаар бодлого боловсруулан хэрэгжүүлэх.

Тээврийн хэрэгсэл, түүний эд ангийг дотоодод үйлдвэрлэх, угсрахад тавигдах техникийн шаардлага, стандартыг боловсруулан мөрдөх.

Тээврийн хэрэгслийн ашиглалт буюу засвар үйлчилгээний бодлого боловсруулан хэрэгжүүлэх.

Авто тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний мэдээллийн санг бий болгох замаар “Үйлчилгээ-Оношилгоо-Хяналтын” нэгдсэн системийг бүрдүүлэх.

Гурав: Хөдөлгөөнд оролцогчдод зориулсан үйл ажиллагаа.

Замын хөдөлгөөнд аюулгүй оролцох мэдлэг боловсрол иргэдэд олгох ажлыг боловсролын тогтолцооны бүх шатанд нэвтрүүлэх.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад олон нийтийн мэдлэг, соёл, ухамсрыг дээшлүүлэх, хууль тогтоомжийг тайлбарлан таниулах ажлыг хүртээмжтэй зохион байгуулах.

Замын аюулгүй байдлын талаархи хууль, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох замаар хөдөлгөөнд оролцогчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх.

Хурд хэтрүүлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ автомашин жолоодох, хамгаалах бүс, малгай хэрэглэхгүй байгаа зөрчлийг онцгойлон анхаарч, урьдчилан сэргийлэх.

Жолооч бэлтгэх, мэргэшүүлэх, шалгалт авах, үнэмлэх олгох тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай

Дөрөв: Ослын дараах тусламж, үйлчилгээ.

Ослын үед гэмтсэн хүнд үзүүлэх яаралтай тусламж, нөхөн сэргээх эмчилгээ болон бусад үйлчилгээний чанарыг сайжруулах.

Анхны тусламж үзүүлэх мэдлэг чадварыг иргэдэд эзэмшүүлэх.

гэмтсэн хүнд цаг алдалгүй тусламж үзүүлэх даатгалын систем болон осол, гэмтлийг тандах системийг бий болгох.

Авто замын сүлжээн дэх эмнэлгийн тусламж үзүүлэх цэгүүдийн тоог нэмэгдүүлж, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжөөр хангах.

Жолооч нарын эмнэлгийн үзлэгийн бүртгэлийг жолоочийн бүртгэлийн системтэй холбох замаар тэднийг эмнэлгийн үзлэгт заавал хамруулах нөхцөлийг бүрдүүлэх.

Стратегийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх ажлыг зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах зайлшгүй шаардлага байна.

Дүгнэлт, санал

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар.

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр дунд болон урт хугацааны үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулан яаралтай хэрэгжүүлэх.

2. Мэргэжилтэй инженер, техникийн ажилтан дутмаг байгаагаас зам, тээврийн инженерийн шийдэл хоцрогдох төдийгүй зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг ямагт жолооч буруутай байх ослын акт, дүгнэлт гардаг тогтолцоог өөрчлөн мэргэжилтнийг сургах, давтан сургах замаар тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх.

3. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байнга хамтран ажиллан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа болон зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгох хөгжөөнт тэмцээн, мэдээ, мэдээллийг тогтмол явуулан хэвшүүлэх.

4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар мэдлэг олгох сургалтыг ерөнхий

боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт заавал тусгаж тэдэнд анхан шатны суурь мэдлэг олгох сургалтыг Замын цагдаагийн газартай хамтран үе шаттай зохион байгуулдаг системийг нэвтрүүлэх.

5. Жолооч бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын арга хэлбэрийг өөрчлөн тэдний мэдлэг ур чадварыг байнга дээшлүүлэхэд чиглэсэн насан туршийн боловсрол олгох кредит системийг сургалтын хэлбэрт шилжин, тэдний үүрэг, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох.

Хоёр. Зам орчин, нөхцөлийг сайжруулах талаар.

1. Монгол Улсын автозамын цахим мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох, орон нутгийн замд аврах, тусламжийн төвүүдийг нэвтрүүлэх.

2. Тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөн хоёрын хоорондын огтлолцолыг салгахад чиглэсэн томоохон хэмжээний бүтээн байгуулалтыг хотын төлөвлөлттэй уялдуулан үе шаттайгаар хийж гүйцэтгэх (гүүрэн байгууламж, нүхэн гарц, инженерийн бусад шийдэл).

3. Замын болон гүүрэн байгууламж бусад дэд бүтцийн урсгал засвар тээврийн хэрэгсэл зорчиход саад болох, нөлөөлөх эвдрэл гэмтлийн засварыг тодорхой байгууллага, нэгжид хариуцуулах замаар цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж байх урамшуулал болон хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх.

4. Мэдээлэх тэмдгийг хот суурин, орон нутгын замуудад сайжруулах.

5. Замын постуудын үйл ажиллагааг сайжруулах шугаман хяналтыг хийж эхлүүлэх орон нутгийн замын хяналтын үйл ажиллагааг сайжруулах.

Гурав. Тээврийн хэрэгсэлийн талаар.

1. Монгол Улсад орж 20-оос дээж жил болсон тээврийн хэрэгслийг насжилтаар нь хасах, 10-аас дээш болсон тээврийн хэрэгслийг үе шаттайгаар цөөлөх бодлого хэрэгжүүлэх.

2. Импортоор орж ирж байгаа тээврийн хэрэгслийн чанарыг сайжруулах үүднээс үйлдвэрлсэн он хуучин тээврийн хэрэгсэлийн татварыг нэмэх, түүнчлэн Монгол Улсын замын хөдөлгөөнд тохируулж баруун талдаа хүрдтэй тээврийн хэрэгсэл импортыг үе шаттайгаар цөөлөх бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэлээ.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. (шинэчилсэн найруулга). 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их хурлаас баталсан. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn/law/details/11224>
2. Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм. Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 74 дүгээр тогтоолоор баталсан.
3. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 279 дүгээр тогтоол. Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр. Төлөвлөгөө. Цахим эх сурвалж, холбоос: <http://bzemn.ub.gov.mn>
4. П.Ганхуяг. Зам тээврийн хэрэг, ослын гаралтыг бууруулах ажлын удирдлага, зохион байгуулалт. Удирдахуйн ухааны магистрын ажил. - УБ., 2015.
5. ЦЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газар. Үйл ажиллагааны эрсдлийн үнэлгээний тайлан. - УБ., 2015.
6. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Нийслэлийн засаг даргын Тамгын газар. Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө. Цахим эх сурвалж, холбоос: http://open.jicareport.jica.go.jp/pdf/247928_01.pdf